

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
2026 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ ЭВСЭЛ,  
НЭР ДЭВШИГЧДИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ  
ХЯНАЖ НЭГТГЭСЭН ДҮНГИЙН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДУАГ-2026/-70-ШТА-НА/

Мандалговь хот 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох  
Утас: 70592439

Аудитын менежер Т.Батсайхан  
Утас: 70592225

Цахим хаяг: [dundgovi@audit.gov.mn](mailto:dundgovi@audit.gov.mn)

Ахлах аудитор Д.Ихбаяр  
Утас: 70592208

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

# АУДИТЫН ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



## ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 10/29

Мөндөлгөн

### Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторовын “Эрх шилжүүлэх тухай” 2025 оны А/175 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1, 3, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж нэгтгэсэн тайланг /ДУА-2026/70/ШТА-НА/-г нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл нэр дэвшигчийн зардлын тайлангийн нэгтгэл дүн, нэг сая ба түүнээс дээш хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш хандив өгсөн хуулийн этгээдийг байгууллагын цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг аудитор /Г.Үүрийнтуяа/-д даалгасугай.

3. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор /Д.Ихбаяр/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Т.Батсайхан/-д тус тус үүрэг болгосугай.



Р.МӨНХТОГТОХ

4826010064

# СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## 1. Аудитын нэр

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх

### Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ” гэж заасныг үндэслэн Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нам эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянаж баталгаажууллаа.

## 2. Аудитын зорилго

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлнэ.

## 3. Аудитын хамрах хүрээ

Аудитад аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланд өгсөн хараат бус хуулийн этгээдийн аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлан, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамруулав.

## 4. Арга зүй

Аудитын ажлыг гүйцэтгэхэд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/27 дугаар тушаалаар баталсан “Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг олон нийтэд мэдээлэх, танилцуулах” журмыг үндэслэлээ.

Нам, эвсэл нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө, нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив, түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвсэл, нэр дэвшигчдээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.

## 5. Үндсэн мэдээлэл

Дундговь аймагт аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны ээлжит сонгуульд 2 намын 7 нэр дэвшигч оролцсон байна. Хүснэгт :1

| Хүснэгт: №1 |                  |     |       |               |
|-------------|------------------|-----|-------|---------------|
| Д/д         | Нам, Эвслийн Нэр | Нам | Эвсэл | Нэр дэвшигчид |
| 1           | Монгол Ардын нам | 1   |       | 3             |
| 2           | Ардчилсан нам    | 1   |       | 4             |

|   |                      |   |  |   |
|---|----------------------|---|--|---|
| 3 | Бие даан нэр дэвшигч |   |  |   |
|   | ДҮН                  | 2 |  | 7 |

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд нэр дэвшсэн 2 нам, 7 нэр дэвшигчид сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулж Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Зардлын хураангуй тайлангаар 2 намын хороо дансаараа орлого авч зарцуулаагүй бөгөөд нэр дэвшигчдийн дансанд нийт 3,851.3 мянган төгрөгийн орлого төвлөрч, сонгуулийн үйл ажиллагааны зардалд бүрэн зарцуулсан байна.

Сонгуульд нэр дэвшигчдэд 3 иргэн 1,850.0 мянган төгрөгийн мөнгөн хандив өгсөн байна. Үүнээс нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн 1 иргэн байна. /Хавсралт № 1/

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудиторын 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/15 дугаар тушаалаар Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчдээс зарцуулах зардлын дээд хэмжээг тухайн тойргоос хамааран 19.7 сая төгрөгөөс 114.3 сая төгрөгийн хооронд тогтоосон бөгөөд нэр дэвшигчид тогтоосон хэмжээнд зардал гаргажээ.

## 6. Сонгуулийн зардлын дансны орлого, зардал

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-д “нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаахувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэж заасны дагуу нөхөн сонгуульд нэр дэвшсэн 9 нэр дэвшигчид сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн байна. Ирүүлсэн тайлангаас 4 тайлан орлого, зарлага тайлагнаагүй “х” тайлан гаргасан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-д “Нам, эвсэл болон нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.” заасны дагуу дансны дугаар, банкны нэрийг 9 нэр дэвшигч хугацаанд нь бүртгүүлсэн байна.

Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлангаарх нийт орлого 3,851.3 мянган төгрөгөөс 1,851.0 мянган төгрөг нь мөнгөн хандив, 2,000.3 мянган төгрөг нь нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, 1.0 мянган төгрөг, нам эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө байна. /Хүснэгт № 2, Хавсралт № 2/

Хүснэгт: №2

| № | ОРЛОГЫН ТӨРӨЛ                  | Нэр дэвшигчийн орлогын дүн /Мян.төг/ |         |     |            | Нийт |         |
|---|--------------------------------|--------------------------------------|---------|-----|------------|------|---------|
|   |                                | Тоо                                  | Мөнгөн  | Тоо | Мөнгөн бус | Тоо  | Мөнгөн  |
| 1 | Намаас оруулсан мөнгөн хөрөнгө | 1                                    | 1.0     |     |            | 1    | 1.0     |
| 2 | Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө  | 2                                    | 2,000.3 | -   | -          | 2    | 2,000.3 |
| 3 | Хуулийн этгээдийн хандив       | -                                    | -       | -   | -          | -    | -       |
| 4 | Иргэний хандив                 | 3                                    | 1,851.0 | -   | -          | 3    | 1,851.0 |
|   | ДҮН                            | 6                                    | 3,851.3 | -   | -          | 5    | 3,851.3 |

Нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 3,851.3 мянган төгрөг зарцуулснаас сонгуулийн зардалд 3,847.6 мянга, бусад зардалд 3.7 мянган төгрөгийг зарцуулжээ. /Хүснэгт: №3, Хавсралт: №3/

Хүснэгт № 3

| №                                | Зардлын төрөл          |                                                                                             | Нэр дэвшигчийн зардлын дүн /Мян.төг/ |
|----------------------------------|------------------------|---------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------|
| ЗАРДЛЫН АНГИЛАЛ НИЙТ ЗАРДЛЫН ДҮН |                        |                                                                                             | 3,851.3                              |
| 2.1                              | Сонгуулийн зардлын дүн |                                                                                             | 3,847.6                              |
|                                  | 2.1.1                  | Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах                             | -                                    |
|                                  | 2.1.2                  | Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах | -                                    |
|                                  | 2.1.3                  | Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал                  | -                                    |
|                                  | 2.1.4                  | Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал-Шатахуун                                   | 497.1                                |
|                                  | 2.1.5                  | Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал /Урамшуулал/                          | 3,350.5                              |
|                                  | 2.1.6                  | Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал                                     | -                                    |
|                                  | 2.1.7                  | Цахим орчин ашиглах зардал                                                                  | -                                    |
|                                  | 2.1.8                  | Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал                           | -                                    |
| 2.2                              | Бусад зардлын дүн      |                                                                                             | 3.7                                  |

Нэр дэвшигчдийн зардлын тайланд сонгуулийн сурталчилгааны урамшууллын зардалд 3,350.5 мянган төгрөг олгосон байна.

## 7. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив:

Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл дутуу, буцах хаяг тодорхойгүй зэрэг шалтгаантай буцаагдсан хандив байхгүй байна. Аудитын хуулийн этгээд хийсэн хяналтаар хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивын орлоготой холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

## 8. Сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын илрүүлэлт:

Аудитын хуулийн этгээд нь Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/31 дугаар тушаалаар баталсан “Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг олон нийтэд мэдээлэх, танилцуулах” журмын дагуу аудит хийж баталгаажуулсан байна. Аудитын хуулийн этгээдийн хийсэн аудитаар алдаа зөрчил илрээгүй бөгөөд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар дахин хянахад алдаа зөрчил илрээгүй. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-д “Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.” заасны дагуу данс байршуулсан банкны захирал нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны хуулгыг ирүүлэхээс бүх банк хугацаандаа ирүүлсэн.

## 9. Аудитын дүгнэлт

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчдийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан сонгуулийн зардлын тайлан нь бүгд үнэн зөв, иж бүрэн илэрхийлэгдсэн дүгнэлт гарсан байна.

# ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТУУД

Хавсралт № 1

**Орон нутгийн 2026 оны нөхөн сонгуульд нэр дэвшсэн нэр дэвшигчид 1 сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэдийн жагсаалт**

/Мянган төгрөг/

| №                      | Тойр- гийн ду- гаар                                                           | Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр | Нэр дэвшигчийн овог нэр | Хандив өгсөн этгээдийн овог нэр | Регистер   | Мөнгөн дүн     |
|------------------------|-------------------------------------------------------------------------------|---------------------------------|-------------------------|---------------------------------|------------|----------------|
| 1                      | 2                                                                             | 3                               | 4                       | 5                               | 6          | 7              |
| 1                      | Дундговь аймгийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль 16 дугаар тойрог /Дэрэн сум / | Ардчилсан нам                   | Н.Бямбасүрэн            | П.Цэцэгням                      | ЦГ68032047 | 1,000.0        |
| <b>Хандив нийт дүн</b> |                                                                               |                                 |                         |                                 |            | <b>1,000.0</b> |

**Аймаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын  
санхүүжилт**

/мянган төгрөг/

| № | Тойргийн дугаар                                                                      | Нэр<br>дэвшүүлсэн<br>нам,<br>эвслийн<br>нэр | Нэр<br>дэвшигчийн<br>овог | Нэр<br>дэвшигчийн<br>нэр | Нийт<br>орлогын<br>дүн | Үүнээс:                                    |                                  |                                             |          |                                |                |
|---|--------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------|---------------------------|--------------------------|------------------------|--------------------------------------------|----------------------------------|---------------------------------------------|----------|--------------------------------|----------------|
|   |                                                                                      |                                             |                           |                          |                        | Нам, эвслээс<br>оруулсан мөнгөн<br>хөрөнгө | Нэр дэвшигчийн<br>өөрийн хөрөнгө | Хуулийн<br>этгээдийн өгсөн<br>мөнгөн хандив |          | Иргэний өгсөн<br>мөнгөн хандив |                |
|   |                                                                                      |                                             |                           |                          |                        |                                            |                                  | Тоо                                         | Дүн      | Тоо                            | Дүн            |
| 1 | 2                                                                                    | 3                                           | 4                         | 5                        | 6                      | 7                                          | 8                                | 9                                           | 10       | 11                             | 12             |
| 1 | Дундговь аймгийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль 16 дугаар тойрог /Дэрэн сум /        | Монгол ардын нам                            | Доржпалам                 | Жамбалрагчаа             | -                      |                                            |                                  |                                             |          |                                |                |
| 2 | Дундговь аймгийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль 16 дугаар тойрог /Дэрэн сум /        | Ардчилсан нам                               | Нацаг                     | Бямбасүрэн               | 1,851.0                | 1.0                                        |                                  |                                             |          | 3                              | 1,850.0        |
| 3 | Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуулийн 4 дүгээр тойрог  | Ардчилсан нам                               | Золбоот                   | Буманбаяр                | -                      |                                            |                                  |                                             |          |                                |                |
| 4 | Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуулийн 2 дугаар тойрог | Монгол ардын нам                            | Адъяасүрэн                | Амарбаатар               | -                      |                                            |                                  |                                             |          |                                |                |
| 5 | Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуулийн 2 дугаар тойрог | Ардчилсан нам                               | Болдбаатар                | Буяннэмэх                | 0.3                    |                                            | 0.3                              |                                             |          |                                |                |
| 6 | Дундговь аймгийн Луус сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуулийн 2 дугаар тойрог         | Монгол ардын нам                            | Догсом                    | Энхбаатар                | -                      | -                                          | -                                |                                             | -        |                                | -              |
| 7 | Дундговь аймгийн Луус сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуулийн 2 дугаар тойрог         | Ардчилсан нам                               | Жамъянлхам                | Март                     | 2,000.0                | -                                          | 2,000.0                          |                                             | -        |                                | -              |
|   | <b>Нийт орлогын дүн</b>                                                              |                                             |                           |                          | <b>3,851.3</b>         | <b>1.0</b>                                 | <b>2,000.0</b>                   | <b>-</b>                                    | <b>-</b> | <b>3</b>                       | <b>1,850.0</b> |

## Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын зарцуулалт

/мянган төгрөг/

| № | Тойр- гийн ду- гаар                                                                  | Нэр дэвшүүлсэн<br>нам, эвслийн<br>нэр | Нэр<br>дэвшигчийн<br>овог | Нэр дэвшигчийн<br>нэр | Нийт зардлын дүн |                                                                        |                                                                                           |                |
|---|--------------------------------------------------------------------------------------|---------------------------------------|---------------------------|-----------------------|------------------|------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------|----------------|
|   |                                                                                      |                                       |                           |                       |                  | Сонгогчидтой<br>уулзалт, хурал,<br>цуглаан хийх<br>зардал-<br>Шатахуун | Сонгууль<br>эрхэлсэн<br>байгууллагын үйл<br>ажиллагааны<br>зардал<br><i>/Урамицуулал/</i> | Бусад зардал   |
| 1 | 2                                                                                    | 3                                     | 4                         | 5                     | 6                | 10                                                                     | 11                                                                                        | 15             |
| 1 | Дундговь аймгийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль 16 дугаар тойрог /Дэрэн сум /        | Монгол ардын<br>нам                   | Доржпалам                 | Жамбалрагчаа          | -                |                                                                        |                                                                                           |                |
| 2 | Дундговь аймгийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль 16 дугаар тойрог /Дэрэн сум /        | Ардчилсан нам                         | Нацаг                     | Бямбасүрэн            | 1,851.0          |                                                                        | 1,850.0                                                                                   | 1.0            |
| 3 | Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуулийн 4 дүгээр тойрог  | Ардчилсан нам                         | Золбоот                   | Буманбаяр             | -                |                                                                        |                                                                                           |                |
| 4 | Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуулийн 2 дугаар тойрог | Монгол ардын<br>нам                   | Адъяасүрэн                | Амарбаатар            | -                |                                                                        |                                                                                           |                |
| 5 | Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуулийн 2 дугаар тойрог | Ардчилсан нам                         | Болдбаатар                | Буяннэмэх             | 0.3              |                                                                        |                                                                                           | 0.3            |
| 6 | Дундговь аймгийн Луус сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуулийн 2 дугаар тойрог         | Монгол ардын<br>нам                   | Догсом                    | Энхбаатар             | -                |                                                                        |                                                                                           |                |
| 7 | Дундговь аймгийн Луус сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуулийн 2 дугаар тойрог         | Ардчилсан нам                         | Жамъянлхам                | Март                  | 2,000.0          | 497.1                                                                  | 1,500.5                                                                                   | 2.4            |
|   | <b>Нийт зардлын дүн</b>                                                              |                                       |                           |                       | <b>3,851.3</b>   | <b>497.1</b>                                                           | <b>3,350.5</b>                                                                            | <b>3,710.0</b> |